

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/196/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ж.Баясгалан Утас: 7036-3047 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСУХ	Биеийн тамир спортын улсын хороо
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БТСГ	Биеийн тамир, спортын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА
У.БАТМӨНХ ТАНАА

2026.08.06 № СЭА-2026/196/НА
танай -ны № - СЭА-ТМЗ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газар нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөрөнгө оруулалтаар 31,200.0 мянган төгрөгийн өртөг бүхий 10 ширхэг компьютер, 12,450.0 мянган төгрөгийн өртөг бүхий тавилга, эд хогшил зэрэг нийт 43,650.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 49 дүгээр тогтоолоор Байгаль орчны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 24,950.0 мянган төгрөгийн өртөгтэй суудлын автомашиныг балансаас балансад шилжүүлж авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар нь тайлант онд өмнө нь мөрдөж байсан хөдөлмөрийн дотоод журмыг хүчингүй болгож, шинэчилсэн хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдөж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 6 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.6 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Код	Үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		228,667,568.75	230,025,823.75
35	БАРАА МАТЕРИАЛ	6	228,667,568.75	230,025,823.75
35100	Түүхий эд материал		135,131,036.00	136,672,436.00
35110	Тусгай зориулалттай материал		135,131,036.00	136,672,436.00
35400	Хангамжийн материал		93,536,532.75	93,353,387.75
35410	Бичиг хэргийн материал		3,312,380.00	2,034,270.00
35420	Аж ахуйн материал		59,242,922.75	63,040,487.75
35470	Бусад хангамжийн материал		30,981,230.00	28,278,630.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		9,023,165,895.47	8,608,889,692.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	9,023,165,895.47	8,608,889,692.21
39200	Биет хөрөнгө		8,788,623,951.03	8,399,399,414.45
39201	Барилга, байгууламж, орон сууц		9,095,246,863.00	9,095,246,863.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-1,344,182,081.84	-1,523,294,657.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл		47,166,666.71	72,116,666.71
39204	Хуримтлагдсан элэгдэл		-39,044,907.88	-52,593,287.32
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		993,214,377.82	1,050,827,760.82
39206	Хуримтлагдсан элэгдэл		-96,926,706.05	-358,502,661.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		89,231,543.00	98,283,160.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		-35,296,290.89	-39,072,810.63
39214	Бусад үндсэн хөрөнгө		235,140,189.17	235,140,129.17
39215	Хуримтлагдсан элэгдэл		-155,925,702.01	-178,751,748.61
39300	Биет бус хөрөнгө		234,541,944.44	209,490,277.76
39301	Программ хангамж		75,530,000.00	75,530,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-3,048,055.56	-28,099,722.24
39303	Бусад биет бус хөрөнгө		162,060,000.00	162,060,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		9,251,833,464.22	8,838,915,515.96
4	Нийт өр төлбөрийн дүн		8,524.02	0.00
41	Богино хугацаат өр төлбөр		8,524.02	0.00
413	Өглөг	9	8,524.02	0.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		8,524.02	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		9,251,824,940.20	8,838,915,515.96
51	Засгийн газрын хувь оролцоо		9,251,824,940.20	8,838,915,515.96
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,086,045,198.00	1,086,045,198.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		1,086,045,198.00	1,086,045,198.00
51200	Хуримтлагдсан үр дүн		7,780,318,470.49	7,367,409,046.25
51210	Өмнөх үеийн үр дүн		7,134,657,383.96	7,780,318,470.49
51220	Тайлант үеийн үр дүн		645,661,086.53	-412,909,424.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		385,461,271.71	385,461,271.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		9,251,833,464.22	8,838,915,515.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Код	Үзүүлэлт	Тод-руулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	4,094,653,238.82	4,106,137,568.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		887,330,986.00	4,106,137,568.72
120	Нийтлэг татварын бус орлого		887,330,986.00	211,186,523.24
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		883,860,986.00	126,787,220.64
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3,470,000.00	0.00
122	Тусламжийн орлого		0.00	3,894,951,045.48
1221	Хандив тусламж /дотоод/		0.00	3,894,951,045.48
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		0.00	3,704,844,700.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого /Улсын төсөв/		0.00	2,203,283,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого /Орон нутгийн төсөв/		0.00	1,501,560,800.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	3	0.00	190,106,345.48
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0.00	189,106,345.48
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0.00	1,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		0.00	84,399,302.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,207,322,252.82	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,905,626,400.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,905,626,400.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		187,815,964.60	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		32,023,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		54,818,810.60	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,610,200.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		88,363,954.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,113,879,888.22	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		1,113,879,888.22	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		3,448,992,152.29	4,517,342,822.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,448,992,152.29	4,517,342,822.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,206,121,019.21	4,202,075,757.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,292,679,766.80	1,709,853,697.80

210101	Үндсэн цалин	792,682,251.20	1,007,379,345.22
210102	Нэмэгдэл	319,135,776.60	419,685,953.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	116,170,000.00	176,934,448.95
210104	Урамшуулал	64,691,739.00	105,853,950.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,442,703.12	182,104,285.25
210201	Тэтгэврийн даатгалын зардал	98,516,627.26	126,041,624.33
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	12,811,841.02	15,882,503.55
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	7,337,248.67	9,339,307.25
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,903,819.48	6,116,249.34
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	19,873,166.69	24,724,600.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,081,479,906.70	1,451,680,716.79
210301	Гэрэл, цахилгаан	65,867,392.03	105,369,978.18
210302	Түлш, халаалт	947,615,511.67	1,288,886,454.61
210303	Цэвэр, бохир ус	67,997,003.00	57,424,284.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,839,199.62	44,054,255.00
210401	Бичиг хэрэг	4,076,030.00	4,451,960.00
210402	Тээвэр, шатахуун	4,220,000.00	5,245,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,244,649.62	3,901,178.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,633,220.00	22,243,917.00
210408	Бараа материал акталсны зардал	13,485,300.00	7,972,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,010,981.52	57,516,583.21
210604	Урсгал засвар	79,010,981.52	57,516,583.21
2107	Томилолт, зочны зардал	3,002,500.00	1,134,200.00
210702	Дотоод албан томилолт	3,002,500.00	1,134,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,938,850.00	4,121,356.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,100,500.00	1,653,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	490,500.00	1,058,506.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	153,450.00	185,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,500.00	920,500.00
210807	Газрын төлбөр	148,900.00	248,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	546,727,111.45	751,610,663.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	218,998,300.00	189,236,410.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	327,728,811.45	562,374,253.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	242,871,133.08	315,267,065.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,011,457.00	315,267,065.01
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,052,172.00	102,597,852.84
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,539,485.00	202,920,212.17
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,419,800.00	9,749,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	189,859,676.08	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	188,867,640.46	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	992,035.62	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	645,661,086.53	- 411,205,253.80

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0.00	1,704,170.44
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		0.00	1,704,170.44
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		0.00	-1,704,170.44-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	645,661,086.53		-412,909,424.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,207,322,252.82	3,979,350,348.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	3,979,350,348.08
122	Тусламжийн орлого	0.00	3,979,350,348.08
1221	Хандив тусламж /дотоод/	0.00	3,979,350,348.08
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.00	3,704,844,700.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого /Улсын төсөв/	0.00	2,203,283,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого /Орон нутгийн төсөв/	0.00	1,501,560,800.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	274,505,648.08
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	189,106,345.48
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	84,399,302.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,207,322,252.82	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,905,626,400.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,905,626,400.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	187,815,964.60	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,023,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,818,810.60	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,610,200.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,363,954.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,113,879,888.22	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,113,879,888.22	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,150,302,852.82	3,753,415,135.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,150,302,852.82	3,753,415,135.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,907,431,719.74	3,641,068,283.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,292,679,766.80	1,709,853,697.80
210101	Үндсэн цалин	792,682,251.20	1,007,379,345.22
210102	Нэмэгдэл	319,135,776.60	419,685,953.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	116,170,000.00	176,934,448.95

210104	Урамшуулал	64,691,739.00	105,853,950.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,434,179.10	182,112,809.27
210201	Тэтгэврийн даатгалын зардал	98,508,103.24	126,385,842.87
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	12,811,841.02	15,882,503.55
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	7,337,248.67	8,956,727.73
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,903,819.48	6,163,134.34
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	19,873,166.69	24,724,600.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,081,479,906.70	1,451,680,716.79
210301	Гэрэл, цахилгаан	65,867,392.03	105,369,978.18
210302	Түлш, халаалт	947,615,511.67	1,288,886,454.61
210303	Цэвэр, бохир ус	67,997,003.00	57,424,284.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,173,785.62	40,997,110.00
210401	Бичиг хэрэг	2,940,150.00	3,173,850.00
210402	Тээвэр, шатахуун	4,220,000.00	5,245,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,244,649.62	3,901,178.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	41,588,986.00	28,437,082.00
2105	Нормативт зардал	3,520,000.00	0.00
210503	1Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,520,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	97,843,481.52	62,511,583.21
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,941,000.00	4,995,000.00
210604	Урсгал засвар	78,902,481.52	57,516,583.21
2107	Томилолт, зочны зардал	3,002,500.00	1,134,200.00
210702	Дотоод албан томилолт	3,002,500.00	1,134,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,938,850.00	4,121,356.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,100,500.00	1,653,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	490,500.00	1,058,506.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	153,450.00	185,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,500.00	920,500.00
210807	Газрын төлбөр	148,900.00	248,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	220,359,250.00	188,656,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	220,359,250.00	188,656,810.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	242,871,133.08	112,346,852.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,011,457.00	112,346,852.84
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,052,172.00	102,597,852.84
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,539,485.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,419,800.00	9,749,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	189,859,676.08	202,920,212.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	189,859,676.08	202,920,212.17
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	57,019,400.00	225,935,212.17
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	57,019,400.00	23,015,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	57,019,400.00	23,015,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	57,019,400.00	23,015,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	57,019,400.00	23,015,000.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-57,019,400.00	-23,015,000.00
----	--	----------------	----------------



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээ-ний нэмэг-дэл	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Нийт дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,086,045,198.00	385,461,271.71	7,134,657,383.96	0.00	8,606,163,853.67
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,134,657,383.96	0.00	8,606,163,853.67
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	645,661,086.53	0.00	645,661,086.53
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,780,318,470.49	0.00	9,251,824,940.20
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,780,318,470.49	0.00	9,251,824,940.20
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,780,318,470.49	0.00	9,251,824,940.20
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-412,909,424.24	0.00	412,909,424.24
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,367,409,046.25	0.00	8,838,915,515.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,905,017,000.00	3,533,244,054.44	371,772,945.56	90.48
12	Татварын бус орлого	3,905,017,000.00	3,533,244,054.44	371,772,945.56	90.48
120	Нийтлэг татварын бус орлого	20,000,000.00	29,601,730.00	-9,601,730.00	148.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	20,000,000.00	29,601,730.00	-9,601,730.00	148.01
122	Тусламжийн орлого	3,885,017,000.00	3,503,642,324.44	381,374,675.56	90.18
122005	Төсвөөс санхүүжих Улсын төсөв/	2,377,309,700.00	2,002,081,524.44	375,228,175.56	84.22
122005	Төсвөөс санхүүжих Орон нутгийн төсөв/	1,507,707,300.00	1,501,560,800.00	6,146,500.00	99.59
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,905,017,000.00	3,533,244,054.44	371,772,945.56	90.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,905,017,000.00	3,533,244,054.44	371,772,945.56	90.48

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,905,017,000.00	3,533,244,054.44	371,772,945.56	90.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,830,212,100.00	1,684,847,707.65	145,364,392.35	92.06
210101	Үндсэн цалин	1,024,587,400.00	1,007,379,345.22	17,208,054.78	98.32
210102	Нэмэгдэл	492,342,500.00	394,679,962.92	97,662,537.08	80.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	188,596,400.00	176,934,448.95	11,661,951.05	93.82
210104	Урамшуулал	124,685,800.00	105,853,950.56	18,831,849.44	84.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,193,500.00	179,958,063.94	46,235,436.06	79.56
210201	Тэтгэврийн даатгал	158,039,000.00	124,934,291.28	33,104,708.72	79.05
210202	Тэтгэмжийн даатгал	17,113,600.00	15,640,489.66	1,473,110.34	91.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,614,100.00	8,835,718.41	-221,618.41	102.57
210204	Ажилгүйдлийн даатгал	8,484,500.00	6,097,513.03	2,386,986.97	71.87
210205	Эрүүл мэндийн даатгал	33,942,300.00	24,450,051.56	9,492,248.44	72.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,417,707,300.00	1,451,680,716.79	-33,973,416.79	102.40
210301	Гэрэл, цахилгаан	92,373,400.00	105,369,978.18	-12,996,578.18	114.07
210302	Түлш, халаалт	1,256,568,500.00	1,288,886,454.61	-32,317,954.61	102.57
210303	Цэвэр, бохир ус	68,765,400.00	57,424,284.00	11,341,116.00	83.51
2104	Хангамж, бараа материалын зардал	14,602,800.00	12,470,380.01	2,132,419.99	85.40
210401	Бичиг хэрэг	1,437,900.00	1,750,200.00	-312,300.00	121.72
210402	Тээвэр, шатахуун	1,494,500.00	1,745,000.00	-250,500.00	116.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,991,000.00	3,572,808.01	-581,808.01	119.45
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,195,400.00	220,000.00	975,400.00	18.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,484,000.00	5,182,372.00	2,301,628.00	69.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,000,000.00	49,880,083.21	40,119,916.79	55.42
210604	Урсгал засвар	90,000,000.00	49,880,083.21	40,119,916.79	55.42
2107	Томилолт, зочны зардал	1,134,200.00	1,134,200.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,134,200.00	1,134,200.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,657,800.00	1,651,350.00	1,006,450.00	62.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	593,000.00	592,000.00	1,000.00	99.83
210803	Даатгалын үйлчилгээ	995,400.00	0	995,400.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,500.00	185,450.00	50.00	99.97
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	620,000.00	610,000.00	10,000.00	98.39
210807	Газрын төлбөр	208,900.00	208,900.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,089,900.00	46,074,700.00	11,015,200.00	80.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,089,900.00	46,074,700.00	11,015,200.00	80.71

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	265,419,400.00	105,546,852.84	159,872,547.16	39.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	265,419,400.00	105,546,852.84	159,872,547.16	39.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	102,697,900.00	102,597,852.84	100,047.16	99.90
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	159,772,500.00	0.00	159,772,500.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,949,000.00	2,949,000.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	64	62	2.00	96.88
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36	34	2.00	94.44
620003	Үйлчлэх ажилтан	27	27	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		243,186,081.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		243,186,081.47
122	Тусламжийн орлого		243,186,081.47
1221	Хандив тусламж /дотоод/		243,186,081.47
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		243,186,081.47
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		189,106,345.48
	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		53,079,735.99
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		243,186,081.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ		243,186,081.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		243,186,081.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		27,160,735.48
210102	Нэмэгдэл		25,005,990.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,154,745.33
2104	Хангамж, бараа материалын зардал		28,526,729.99
210401	Бичиг хэрэг		1,423,650.00
210402	Тээвэр, шатахуун		3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		328,369.99
210405	Хог хаягдал зайлуулах		20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		23,254,710.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		35,646,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		28,010,000.00
210604	Урсгал засвар		7,636,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,470,006.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,061,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		1,058,506.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		310,500.00

210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр		40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		142,582,110.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		142,582,110.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		6,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,800,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар /цаашид БТСГ гэх/ нь ард иргэд, хүүхэд, залуучуудыг биеийн тамирын арга хэмжээгээр дамжуулан бялдаржуулах, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт сургах насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх “Өөртөө цаг гаргая” гэсэн уриаг зорилго болгон нийтийг хамарсан биеийн тамир, спортын 237 төрлийн арга хэмжээг төрийн бус байгууллагууд, спортын холбоодтой хамтран сар бүр зохион байгуулж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр Монгол Улсын Төсвийн тухай хуульд төсөв, хариуцлагатай холбоотой, Төрийн албаны тухай хуульд хариуцлагатай холбоотой нэмэлт өөрчлөлтүүд тус тус орсон,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.1 дэх хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

БТСГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд БТСУХ-ноос сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

БТСГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа бөгөөд уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

БТСГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 412,918.0 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	228,667.6	230,025.8	1,358.3
Үндсэн хөрөнгө	9,023,165.9	8,608,889.7	-414,276.2
Нийт хөрөнгө	9,251,833.5	8,838,915.5	-412,918.0
Өглөг	8.5	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,251,824.9	8,838,915.5	-412,909.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,251,833.5	8,838,915.5	-412,918.0

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна.
Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 230,025.8 мянган төгрөг болж 1,358.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 88,480.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон үйл ажиллагаанд 79,149.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, цаашид ашиглах боломжгүй 7,972.2 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассанаас голлон шалтгаалсан,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,608,889.7 мянган төгрөг болж 414,276.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 23,015.0 мянган төгрөгийн

тоног төхөөрөмж худалдан авч, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөрөнгө оруулалтаар 31,200.0 мянган төгрөгийн өртөг бүхий 10 ширхэг компьютер, 12,450.0 мянган төгрөгийн өртөг бүхий тавилга, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 49 дүгээр тогтоолоор Байгаль орчны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 24,950.0 мянган төгрөгийн өртөгтэй суудлын автомашиныг балансаас балансад шилжүүлэн авч, анхны өртгөөрөө элэгдлээ нөхсөн 77,900.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж, дахин үнэлсэн зэргээс шалтгаалсан,

- Өглөг дансны үлдэгдэл 8.5 мянган төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбоотой өглөгийг барагдуулсантай холбоотой байна.
- Программ хангамжийн зардалд 930.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас санхүүгийн программын төлбөрт 560.5 мянган төгрөгийг, усан бассейны программын сунгалтын төлбөр болон программын өөрчлөлтөд 360.0 мянган төгрөг зэрэг нийт 920.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,763,596.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,438,246.3 мянган төгрөг, нийт зарлагыг 4,201,843.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 18,273.0 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2,284.2 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 63,902.1 мянган төгрөгөөр,
- Эд хогшил урсгал засварын зардлыг 163,578.0 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 5,200.0 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийг 121,937.5 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 42,535.5 мянган төгрөгөөр зэрэг нийт 417,710.3 мянган төгрөгөөр бууруулж,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 120,012.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 69,461.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж нийт 3,973,605.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 68,588.8 мянган төгрөгөөр бууруулж, 3,905,017.0 мянган төгрөг болгон тодотгол, зохицуулалт хийж эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 19,086.2 мянган төгрөгөөр,



- Хангамж бараа материалын зардлыг 62.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 197.2 мянган төгрөгөөр,
- Эд хогшил урсгал засварын зардлыг 5,600.0 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 2,365.8 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 69,402.1 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийг 6,256.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3,916.7 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,377,309.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,507,707.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 20,000.0 мянган төгрөг нийт 3,905,017.0 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,203,283.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,501,560.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 29,601.7 мянган төгрөг нийт 3,374,446.4 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлсэн бөгөөд батлагдсан төсөвтэй харьцуулахад улсын төсвөөс 174,025.8 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,533,244.0 мянган төгрөг буюу 90.5 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшлын зардлыг 145,364.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 46,235.4 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 40,119.9 мянган төгрөг зэргээр хэмнэснээс голчлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих	2,985.6	2,924.7	60.9	98.0
2	Үндэсний тэмцээн, наадмын үйл ажиллагаа	54,104.3	43,150.0	10,954.3	79.8
3	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,074,207.4	1,879,469.7	194,737.7	90.6
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	265,419.4	105,546.9	159,872.5	39.8
5	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	593.0	592.0	1.0	99.8
6	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	1,507,707.3	1,501,560.8	6,146.5	99.6
	Дүн	3,905,017.0	3,533,244.0	201,202.4	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудитораас өгсөн “Төрийн аудитын байгууллагын 2025-2026 онд гүйцэтгэх аудитын ерөнхий чиглэл”-ийн хүрээнд тус байгууллагаас авсан судалгаанд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн БТСГ-ын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/02 дугаар албан бичгээр хоолны хөнгөлөлтийг өдрийн 12.0 мянган төгрөгөөр тооцож, тайлант онд 176,934.4 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон,
- БТСУХ-ны 2025 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн А/02 тоот тушаалаар төсвийн хуваарь батлахдаа тус газрыг 64 албан хаагчтай байхаар орон тоо баталснаас тайлант онд 62 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж, сул орон тоонд нөхөн томилгоо хийгдээгүй,
- Гадаад томилолтоор ажиллаагүй, хэвлэл, мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээт ажил хийгдээгүй, хурал, цуглаан, форумтай холбоотой зардал гараагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130034410 тоот дансанд нийт 244,903.9 мянган төгрөг орлого төвлөрснөөс 243,186.1 мянган төгрөгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 1,717.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ЗДНХ-өөр 27,160.7 мянган төгрөгийг орон нутгийн нэмэгдэл цалингийн зардалд, 15,857.6 мянган төгрөгийг хүүхдийн өвлийн спортын наадмын зардалд, 74,529.6 мянган төгрөгийг хүүхдийн зуны спортын наадмын зардалд, 25,525.5 мянган төгрөгийг спортын наадмын зардалд, 25,668.4 мянган төгрөгийг бүх ард түмний спартакиадын зардалд, 20,364.5 сая төгрөгийг тоног төхөөрөмж, урсгал засварын болон бараа материалын зардалд гэх мэт нийт 189,106.3 мянган төгрөг,
- Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс 1,000.0 мянган төгрөгийг санхүүжилт ирснийг тэтгэмж, шагнал урамшууллын зардалд,
- Өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 18,046.7 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлсийн зардалд, 17,090.0 мянган төгрөгийг багаж, техник хэрэгслийн зардалд, 5,821.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, 3,800.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, 8,322.1 мянган төгрөгийг бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, хог хаягдал зайлуулах зардалд зэрэг нийт 54,079.7 мянган төгрөгийг урсгал зардалд тус тус зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй бөгөөд тайлант онд шууд худалдан авах босго үнээс

давсан худалдан авалт хийгдээгүй, тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,448,992.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 34,489.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.


4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ Биеийн тамир, спортын газар нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Сумдад ажилладаг ажилчидтай цахимаар хурал, хяналтыг гүйцэтгэж, холбогдон гарах зардлыг хэмнэсэн,
- Сонин, хэвлэл, сэтгүүлийн захиалга хийгээгүй,
- Сул орон тоонд шинээр ажилтан томилогдоогүй бөгөөд цалингийн зардлыг хэмнэсэн гэх мэт...

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 431 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 37,157.4 мянган төгрөгийн дараах алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Мандал сумын спорт цогцолборын ариун цэврийн өрөөний 19,779.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажил,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шагайн харвааны өрөөний 17,377.5 мянган төгрөгийн засварын ажил зэрэг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр буюу шууд зардлыг бараа материалын бүртгэлд бөөн дүнгээр орлогод авч зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.9 “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бараа материалын тайланд бөөн дүнгээр орлого, зарлагаар бүртгэсэн	2	37,157.4					2	37,157.4				
Дүн	2	37,157.4					2	37,157.4				